

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 удаа хуралдаж 12 асуудал хэлэлцэн 10 тогтоол баталлаа. Үүнд:

- "Сэлэнгэ аймагт сум, байгууллагын тэгш ой тэмдэглэх зөвшөөрөл олгох журам"-ыг үндэслэн Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 90 жилийн ойг 2016 оны 08 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрлөө.

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь хангуулан ажилласан, мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлыг жил бүр хангалттай сайн үнэлүүлж ажилласныг харгалзан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжавт нэг сарын үндсэн цалингийн урамшуулал олголоо.

- Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар хуралдаанаас өгсөн үнэлгээг харгалзан аймгийн Засаг дарга С.Бүрэнбатад нэг сарын албан тушаалын үндсэн цалингийн урамшуулал олголоо.

- Цагдаагийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасныг нь үнэлж Монгол улсын Гавьяат хуульч, Цагдаагийн Хурандаа Майдарын Батаевыг Сэлэнгэ аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнав.

- Зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлж зургаагаас доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн 2 эхийг Алдарт эхийн I одонгоор, 4-5 хүүхэд төрүүлж 4-өөс доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн 14 эхийг Алдарт эхийн II одонгоор тус тус шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

- Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дэвсгэрт орших "Гацуурт"-ын ордыг ашиглах "Центерра Гоулд" ХХК-тай орон нутгийн зүгээс хамтран ажиллах гэрээний төсөл боловсруулах, хэлэлцээр хийх ажлын хэсгийг томиллоо.

- Монгол улсын Их Хурлын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны сонгуулийн саналын хуудсыг устгах ажлын хэсгийг байгууллаа.

- Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улс эх орон, аймаг, орон нутгийнхаа хөгжил дэвшилд оруулсан бодитой хувь нэмэр, хөдөлмөрийн амжилтыг нь үнэлж Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Санжжавыг "Сүхбаатарын одон"-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.Төрийн захиргаа, боловсрол, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг төрийн дээд одон, медалиар шагнуулахаар тогтов. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 2, Цэргийн гавьяаны улаан тугийн одон 1, Алтан гадас одон 22, Хөдөлмөрийн хүндэт медаль 12 хүнийг Монгол улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

- Баянгол, Ерөө, Баруунбүрэн сумын хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний бие бялдрыг өв тэгш хөгжүүлэх зорилгоор "Спорт цогцолбор" төсөвт байгууллага байгуулж, дүрмийг хавсралтаар батлав.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд 2016 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр буюу Сэлэнгэ аймагт ажиллаж Сүхбаатар сумын иргэд, хөдөлмөрчилтэй уулзалт зохион байгуулан, Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар

баталсан хууль тогтоомжийн талаар танилцуулга хийж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авлаа.

Хууль зүйн сайдын 2016 оны А/115 тушаалын дагуу 2016 оны 05 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулах “Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн Сэлэнгэ аймаг дахь тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагаа”-г сайжруулах, тэдний албаны бэлэн байдлын жигдрэлт, бэлтгэлжилтийг хангах Команд штабын сургуулийн бэлтгэл хангах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах ажлыг Хууль сахиулах удирдлагын академийн ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулж ажилласан.

Захиргааны ерөнхий хуулийн сургалтыг Хууль зүйн яамтай хамтран 2016 оны 04 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтанд сумдын Засаг даргын Тамгын газар болон, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудын удирдах болон гүйцэтгэх ажилтнууд нийт 201 албан хаагчид хамрагдлаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо” төслөөс “Иргэдийн улс төрийн эрхийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг”-ийг 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдын иргэд, төрийн албан хаагчид оролцлоо.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд тушаалаа. 2015-ийд 14386,2 мян.төг, 93,2 мян.төг, 5325,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 3709,6 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн санхүүжилт авч захиран зарцууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэсБоловсрол, соёлын газар, Эрүүл мэндийн газар хамтран Ерөө сум болон Бугант тосгоны төрийн сангийн үйл ажиллагаа, төсөвт байгууллагуудын цалин тогтоолт, төсөв, төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүүгийн хяналт аудитын алба хамтран Цагааннуур сумын санхүүгийн алба, төсөвт байгууллагуудад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, шинээр гарсан шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам болон бусад хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат 2016 оны 4 дүгээр сарын 24, 25, 26-ны өдрүүдэд Орхон, Орхонтуул сумдад ажиллаж, бүрэн эрхийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний талаар иргэд, хөдөлмөрчдөд мэдээлэл хийн, сум дундын хил орчмын бэлчээрийн газрын асуудлаар иргэдээс гомдол ихээр гарсан тул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд, холбогдох сумдын Засаг даргыг байлцуулан асуудлыг газар дээр нь шийдвэрлэлээ.

“Монгол Улсын тэргүүний сум”-аар тус аймгийн газар тариалангийн өлгий нутаг Цагааннуур сум шалгарч хаврын адаг сарын шинийн 15-ны билэгт сайн өдөр шагналаа гардан авснаар Сэлэнгэ аймаг "Улсын тэргүүний гурван сумтай боллоо.

“Монголд үйлдвэрлэв” Аж үйлдвэрийн чуулган Сэлэнгэ аймагт зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймаг, ОХУ-аас үйлдвэрлэгчид оролцсон бөгөөд арга хэмжээний хүрээнд Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн сан, үйлдвэрийн улсын тооллого, Монгол Улсын шилдэг хүнд, хөнгөн үйлдвэрүүдийн захирлууд туршлагаа хуваалцлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248-р тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүднээс Төрийн орон сууцанд иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах үйл

ажиллагаа Сэлэнгэ аймгийн Мандал суманд зохион байгуулж, нийт 115 иргэн бүртгүүлсэнээс “Төрийн түрээсийн орон сууцанд иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журмын шаардлага хангасан 90 иргэн орон сууц түрээслэх эрх олголоо.

Бусад ажлын талаар:

1. Онцгой байдлын газар:

“Үзвэр үйлчилгээний байгууллагууд”-д гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм норм, стандартын хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд 45 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 146 зөрчил илрүүлж, 19 зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгуулж, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 26, мэдэгдэл 19, дүгнэлт 2, гал түймэр гарсан тухай акт 2-ийг үйлдэж, хууль тогтоомж зөрчсөн, галын аюулгүй байдлын стандарт, норм, дүрмийг хэрэгжүүлээгүй, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагын хариуг ирүүлээгүй 1 иргэнийг 576.000 төгрөгөөр тус тус торгож захиргааны арга хэмжээ ногдууллаа.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын Спортын бүрэн дунд сургуулийн 18 багш, 9 сурагчдад гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж, эмнэлэгийн анхны тусламж сэдвүүдээр танхимын сургалтыг зохион явууллаа.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 12 жилийн 3 дугаар сургууль дээр гал унтраах тактикийн сургууль явагдахтай холбогдуулан Онцгойбайдлын газраас “Объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд анги танхимыг орхин гарч аюулгүй цэгт шилжин байрших, түлэгдэлтийн үеийн анхны тусламж, халдварт хачигт хазуулахаас урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр танхимын сургалтыг зохион байгуулж, 9-11 дүгээр ангийн сурагч, багш ажилчдыг хамрууллаа.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгаас “Аюулт үзэгдэл, ослын тухай ойлголт, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, аюулгүй цэгт шилжин байрших” сэдэвт танхимын сургалт, дадлагыг 2016 оны 04 дүгээр сарын 14 ны өдөр Сүхбаатар сумын 12 жилийн 5 дугаар сургуулийн 9-11 дүгээр ангийн сурагч, багш ажилчдад “Өсвөрийн аврагч” клубын гишүүдийн хамтаар зохион явууллаа.

2. Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс ээлжит баталгаажуулалтаар Ерөө, Хүдэр сум, Бугант тосгонд ажиллаж тохирлын үнэлгээ, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн тухайн сумдын худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт худалдаа үйлчилгээний стандарт, хэмжилзүйн талаар сургалт хийж, холбогдох стандартын талаар мэдээлэл өглөө.

“Хэрэглэгчийн жил”, “Олон улсын хэрэглэгчийн өдөр”-ийг тохиолдуулан аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Ерөө сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Хүдэр, Ерөө сум, Бугант тосгоны худалдаа үйлчилгээ эрхлэгчид болон иргэдийн дунд “Хэрэглэгч таны төлөө” хэрэглэгчийн өдөрлөг зохион байгууллаа.

Сүхбаатар, Ерөө, Хүдэр, Сайхан, Жавхлант, Сант сум, Дулаанхан, Номгон тосгоны 43 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, сумдын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84,0-өөс дээш хувийг хангасан 37 худалдаа, үйлчилгээний газарт, тохирлын гэрчилгээ олголоо.

Стандартын салбар сангаас 2аж ахуй нэгж, иргэний хүсэлтийн дагуу 5 нэрийн 5 стандартаар хангаж, арга зүйн зөвөлгөө өгч, үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар, Сайхан сумын худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 153 жин, 10 туухай нийт 163 хэмжих хэрэгсэл баталгаажууллаа.

Ерөө, Хүдэр, Орхонтуул, Баруунбүрэн сум Хөтөл, Бугант тосгонд үйл ажиллагаа явуулж буй 10 шатахуун түгээх газруудын 34 шатахууны түгээгүүр, 6 мерник, сүмбэнметрийг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

Сүхбаатар, Зүүнбүрэн сумын хүн эмнэлэгийн 43 цусны даралтын аппарат баталгаажуулалтанд хамрагдснаас 38 ширхэгийг баталгаажуулж, 5 ширхэг цусны даралтын аппарат ашиглалтын шаардлага хангахгүй байсан тул ашиглахгүй байх мэдэгдэл хүргүүлээ.

Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх станц ХК-ийн лабораторитой хамтран Сүхбаатар сумын 1, 2, 4, 5, 8-р багийн айл өрхийн нэг фазын 1300 ширхэг цахилгаан тоолуур баталгаажуулах ажлыг гүйцэтгэлээ. Мандал сумын аж ахуй нэгж, байгууллага, иргэний 1 фазын цахилгаан тоолуур баталгаажуулах ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

3. Мэргэжлийн хяналтын газар:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2016 оны 4 дүгээр сарыг “Сүхбаатар, Алтанбулаг сумдад нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг үнэлэх, сайжруулах сар” болгон шийдвэрлэж 6 ажил төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа. Нэгдсэн шалгалтанд 76, зөвлөн туслах үйлчилгээнд 37 хуулийн этгээд, 356 иргэнийг хамруулж, хяналт шалгалтын явцад 640 зөрчил илрүүлж, тэдгээрийг арилгуулахаар 415 заалт бүхий 78 албан шаардлага, 153 заалт бүхий 33 зөвлөмж болон 5 дүгнэлт, 6 акт үйлдэж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан 2,714,000 төгрөгийн торгууль ногдууллаа.

Монгол улсад зохион байгуулагдах АСЕМ-ын уулзалтын аюулгүй байдлын хангуулах ажлын хүрээнд тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт болон аюултай бодис ашиглан үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын газар, Онцгой байдлын газартай хамтарсан шалгалтыг хийж хууль тогтоомж зөрчсөн 2 аж ахуйн нэгжид 384.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, албан шаадлага хүргүүлээ.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

2016 оны 3 сарын гүйцэтгэлээр /мян.төг/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	3,757,504.8	3,356,844.9	89.3
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	2,940,239.6	2,812,546.1	95.7
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	17,705,667.0	15,475,499.9	87.4
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	3,925,714.6	2,908,511.4	74.1
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	297,683.3	91,944.1	30.9
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	125,995.6	60,985.6	48.4
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	80,000.0	62,436.6	78.0
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	514,208.1	333,794.5	64.9
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1,138,200.0	1,138,200.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	11,138,645.6	11,138,645.6	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	5,624,468.7	5,624,468.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	3,017,373.7	3,017,373.7	100.0
	- Эрүүл мэнд, спортын байгууллага	1,577,910.8	1,577,910.8	100.0

	- Соёлын байгууллагуудын	786,723.6	786,723.6	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	54,661.2	54,661.2	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	77,507.6	77,507.6	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	11,138,645.6	11,138,645.6	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	5,624,468.7	5,624,468.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	3,017,373.7	3,017,373.7	100.0
	- Эрүүл мэнд	1,208,824.7	1,208,824.7	100.0
	- Спортын байгууллага	137,686.5	137,686.5	100.0
	- Соёлын байгууллагуудын	231,399.6	231,399.6	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	786,723.6	786,723.6	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	54,661.2	54,661.2	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	77,507.6	77,507.6	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,032,275.5	1,032,275.5	100.0
9	Аймгийн нийт нөөц хөрөнгө гүйцэтгэл	308,524.8	200,388.7	65.0
10	Үүнээс Аймгийн Засаг даргын нөөц	197,576.8	124,253.5	62.9

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Барааны нэр төрөл		2016	2016	2016-II
		II- сар	III- сар	2016-III
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	100
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	100
	Нарийн боов /кг/	2300	2300	100
	Будаа /кг/	2200	2200	100
	Элсэн чихэр /кг/	1800	1800	100
2 МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН				
	Хонины мах /кг/	5000	5500	110.0
	Үхрийн мах /кг/	6000	7200	120.0
	Адууны мах /кг/	4000	4500	112.5
	Ямааны мах /кг/	4000	5000	125.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	3500	3500	100.0
	Хиам /чанасан, кг/	9500	9500	100.0
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ				
	Сүү /задгай, л/	1300	1300	100
	Сүү / савласан, л/	2500	2500	100
	Тараг /задгай, л/	1500	1500	100
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	10000	10000	100
	Айраг /л/	3500	3500	100
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	100
	Өндөг /ш/	300	300	100
4 Бүх төрлийн өөх тос				
	Ургамлын тос /л/	3400	3400	100
	Өөхөн тос /кг/	1500	1500	100
	Шар тос /кг/	9000	9000	100

	Масло /задгай, кг/	5000	5000	100
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1000	1000	100
	Лууван /кг/	2000	2000	100
	Манжин /кг/	2000	2000	100
	Байцаа /кг/	2000	2000	100
	Сонгино /кг/	2000	2000	100
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3000	3000	100
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	100
2	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1480	1480	100.0
	Бензин А - 92	1580	1580	100.0
	Дизелийн түлш	1690	1690	100.0

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016 оны А/93 тоот захирамжийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм хийдэд хяналт шалгалтхийж, бүртгэл судалгааг шинэчлэх ажлыг 4 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт Буддын шашны 12, Христийн шашны 35, Исламын 1 нийт 48 сүм хийд байна.

Аймгийн хэмжээнд энэ оны 1 дүгээр улиралд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

- нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 202 буюу 3.1 хувиар өссөн, гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая.төг/ 354.6 буюу 30.1 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

- хүнийг санаатай алах гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 дахин өссөн
- бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 8 буюу 14.3 хувиар өссөн
- бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 90 буюу 36.4 хувиар өссөн
- хүчиндэх гэмт хэрэг 5 буюу 4 дахин өссөн
- хулгайлах 39 буюу 40.9 хувиар буурсан
- хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 21 буюу 52.3 хувиар буурсан
- мал хулгайлах гэмт хэрэг 18 буюу 10.0 хувиар буурсан
- дээрэмдэх гэмт хэрэг 3 буюу 2 дахин өссөн
- эм бэлдмэл, бодис хууль бусаар тээвэрлэх хэрэг 1 бүртгэгдэж 1 дахин
- ойн хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 9 бүртгэгдэж 8 дахин өссөн
- хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 18 буюу 38.5 хувиар өссөн

Үйлдэгдсэн онцлогоор нь авч үзвэл:

- галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2 дахин өссөн
- согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 844 буюу 82.5 хувиар
- эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 96 буюу 9.4 хувиар өссөн
- гэр бүлийн хүчихийлэл 94 буюу 9.2 хувиар өссөн дүнтэй байна.

1. Архивын талаар:

Хууль зүйн сайдын 2016 оны А/43 тоот тушаалын дагуу Төрийн архивын улсын үзлэгт бэлтгэх тухай аймгийн Засаг даргын 2016 оны А/79 тоот захирамж, улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Цагаатгалын ажлыг зохион байгуулах салбар комиссын 1991-2006 оны 29 хадгаламжийн нэгж, Шаамарын тэжээлийн аж ахуй болон Баянгол сумын Аж ахуйн нэгжүүдийн 1992-1995 оны тушаалуудыг хүлээн авлаа.

Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль, Хушаат сумын Эрүүл мэндийн төв, Номгон тосгоны захирагчийн албаны архив, бичиг хэргийн эрхлэгч нарт архивын гэрчилгээ хөтлөх, устгах хэргийг зөв ангилах, байнга, түр, 70 жилийн бүртгэлийг боловсруулах зэрэг ара зүйн сургалтыг зохион байгууллаа.

Төрийн архивын AMS программд Шаамарын тэжээлийн аж ахуйн 41 хадгаламжийн нэгжний 7395 хуудасны агуулгыг уншиж 6195 заалт, 31280 хүний нэр, 548 байгууллагын нэр, 626 газар зүйн нэрийг шивж орууллаа. Мөн Сумдын Худалдаа бэлтгэлийн анги, Нийтийн ахуй үйлчилгээний газрын нийт 3 дансны 35 хадгаламжийн нэгжийн 5734 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэлээ.

Мастер хувиас ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 16 хадгаламжийн нэгжийн 2283 хуудас баримтыг photoshop программ ашиглан ашиглалтын хувь үүсгэлээ.

Иргэд албан байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу архивын хуулбар 239, архивын магадлагаа, тодорхойлолт 56, цалингийн тодорхойлолт 7 гаргаж өгч үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсролын чиглэлээр:

Аймгийн Боловсрол, соёлын газраас сургуулийн өмнөх боловсролын болон бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулж нийт 350 гаруй багш, арга зүйч, бага, дунд ангийн сургалтын менежер, давхардсан тоогоор 1400 гаруй хүүхэд оролцлоо.

“Зөв Монгол хүүхэд хөтөлбөр-хүүхэд бүрийн хөгжилд” эссэ бичвэрийн сургууль, бүс, аймгийн уралдааныг зохион байгуулж, дүнг БСШУЯ-нд хүргүүлснээс шилдэгэссэгээр Сайхан сумынерөнхий боловсролын сургуулийнэцэгэхийнтөлөөлөлМөнхцэцэг Батламж, 1сая төгрөг, Сүхбаатарсумын Улсын тэргүүний 1 дүгээр сургуулийн 7^гангийнсурагч А.Тэлмэнтусгайбайрэээлж 500,0 мянган төгрөгөөр тус тус шагнууллаа.

Суурь боловсролын урлаг хөтөлбөрийг хөгжмийн сургалттай уялдуулан үндэсний хөгжмийн суурь мэдлэг ойлголт дээр шинэ мэдлэг, мэдээлэл олгох, ардын уламжлалт хөгжмийн зэмсгээ өвлөх, эзэмших хүсэл эрмэлзлийг төрүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгөх үүднээс Боловсрол, соёлын газар, Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-тай хамтран “Надад ойрхон Монгол аялгуу” үндэсний хөгжмөө сурталчлах өдөрлөгийг Бэлчир бүсийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж 1070 сурагчид хамрагдлаа.

2016 он гарсаар улаан бурхан өвчнөөр өвдсөн нийт хүүхдийн болон одоо улаан бурхнаар өвчилсөн байгаа сургууль, цэцэрлэгийн хүүхдийн судалгааг нэгж байгууллага бүрээс авч, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, цэвэрлэгээ үйлчилгээ, халдваргүйтгэлийг хийх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Бэлчир бүсийн англи хэлний багш нарын мэргэжлийн ярианы хичээлийг 7 хоногийн баасан гараг бүр, Энхтайвны корпусын сайн дурын мэргэжилтнүүдтэй хамтран сар бүр сургалт зохион байгуулж, англи хэлний багш нараа чадваржуулж байна.

“Залуу зохион бүтээгч 2016” улсын уралдааны орон нутгийн урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн Сүхбаатар сумын 3, 4 дүгээр сургуулийн багш, сурагчдын бүтээлийг МҮОНТ-ийн бичлэгт оруулж, Монгол Улсын төрийн шагналт, ардын зураач, профессор Д.Амгалангийн нэрэмжит “Амгалан орчлон” гар зургийн улсын анхдугаар уралдаанд 55 сурагчийн бүтээлийг оролцууллаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл 04 дүгээр сарын 25-ны 18.00 цагт дуусаж энэ хичээлийн жилийн төгсөгч 1301, өнгөрсөн оны төгсөгч 92 хүн элсэлтийн

ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлж, мэдээллийн баазыг Боловсролын үнэлгээний төвд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

2. Эрүүл мэнд, биеийн тамирын талаар:

Аймгийн Эрүүл мэндийн газраас нийт сум, тосгодын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, вакциinator нарын 70 хүн оролцсон сургалтыг зохион байгуулж, саагийн 2 цэнт вакцины үйл ажиллагааг аймгийн хэмжээнд эхлүүллээ.

Дэлхийн эмч нарын өдрийг угтаж “Тамирчин эмч” сэдэвт урлаг спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулж тэмцээнд 17 сум, 6 тосгон өрх, хувийн хэвшлийн 80 гаруй эмч нарын бүрэлдэхүүнтэй 8 баг оролцож, оюун мэдлэг, авъяас чадвар, ахваалж, самбаагаа сорин аймгийн Нэгдсэн эмнэлэг түрүүлж, шилжин явах цомын эзэн болсон.

Сум, тосгоны “0-1 насны 2000 гаруй хүүхэд 1-5 насны 450 гаруй суурь өвчтэй хүүхдүүдэд гэрээр их эмчийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, эцэг эхэд нь зөвлөгөө өглөө. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 28,5 хувь нь цус багадалттай рахиттай, жингийн алдагдалтай байгаа нь эцэг, эхийн хүүхэддээ тавих анхаарал, халамж, хоол, тэжээлийг сайжруулах шаардлагатай байгаа дүгнэлт гаргалаа.

Сумдын Засаг даргын Тамгын газрын ажилтнууд Эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэгийн багш ажилтан ард иргэдэд “Улаанбурхан, томуу төст өвчин, Менингококоогийн халдвар, цагаан хорхойн өвчнөөс хэрхэн сэргийлэх, бага насны хүүхдийн эрүүл мэндэд анхаарал тавих талаар сургалтууд хийж 2100 гаруй хүнийг хамрууллаа.

Цэцэрлэгийн хүүхдүүд, багш ажилтнууд, бага ангийн багш тогооч зэрэг 1984 хүнийг цагаан хорхойн үзлэгт хамруулснаас 182 буюу 9,1 хувь нь цагаанхорхой илэрснийг хяналтанд эмчилж байна.

МҮОНРТ-ын нэрэмжит өсвөр үеийн Гандболын улсын аварга шалгаруулах тэмцээнийг Баянгол суманд зохион байгуулж Улаанбаатар хот, Дархан, Булган, Дорноговь, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн 14 байгууллагын 36 багийн 400 гаруй тамирчид оролцлоо.

ОХУ-ын Буриад Улсын Хиагтын ройанд Бөхийн чөлөөт барилдааны Ковер Кяхта тэмцээнд манай аймгаас 10 тамирчин оролцож +69 кг-ын жинд Ц.Лхагваочир алт, 69 кг-ын Б.Хашболд мөнгө, 63 кг-ын жинд Э.Алтанбаяр хүрэл, 42 кг-ын жинд О.Батболд мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.

Ширээний теннисний аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг ганцаарчилсан, холимог хосын төрлөөр зохион байгуулж 4 байгууллагын нийт 48 тамирчин оролцлоо.

Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах волейболын тэмцээний Төв аймагт болсон төвийн бүсийн аймгуудын тэмцээнд Спорт сургуулийн баг, эрэгтэй Мандал сумын 3-р сургуулийн баг тамирчид оролцон эрэгтэй, эмэгтэй баг тамирчид мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ.

3. Нийгмийн даатгалынталаар:

Нийгмийн даатгалын санд 6008.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 6403.2 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 106.6 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 14768 тэтгэвэр авагчдад 11947.4 сая төгрөгийг олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас 1420 даатгуулагчдад 461.0 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олголоо.

Үйлдвэрлэлийн осол мэргэшлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 237 даатгуулагчид 277.2 сая төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж,

сувилалын зардалд олгосон бол, ажилгүйдлийн даатгалын сангаас 189 даатгуулагчдад 219.7 сая төгрөгний ажилгүйдлийнтэтгэмжолгожээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг эмийн сангуудад 859.7 сая төгрөгийн эмчилгээний болон эмийн эмийн үнийн хөнгөлөлт үзүүллээ

Шинээр нийгмийн даатгалд 8 аж ахуй нэгжийг хамруулж 25 заавал даатгуулагчаар хамрагдалт нэмэгдлээ.

4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2446 иргэнд 224.2 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1348 иргэнд 59.3 сая төгрөгийг олголоо.

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 102иргэнд 48.7 сая төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 853 иргэнд 1.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 68 иргэнд 7.6 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт үйлчилгээг үзүүллээ.

Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2085 эхэд 87.8 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 42 иргэнд 6.2 сая, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 1024 иргэнд 12.4 сая төгрөгийг олголоо.

Эхийн алдар одонтой 7833 эхчүүдэд 8.0 сая төгрөгийн тусламжийг үзүүллээ.

5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2016 оны 03-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 874 байсан бол 241 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 43 ажлын байранд 38 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 68 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1009 боллоо.

Аймгийн хэмжээнд “Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл мэндийг сайжруулах нь” сэдэвт сарын аяны нээлтийг 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Онцгой байдлыг газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, зүтгүүрийн депо, Магнай трейд шатахуун түгээх станц, Шинэ бадрах ХХК, Нэгдсэн эмнэлэг, Урсгал ус ХХК, Хилийн цэргийн 0243-р анги, Дархан Сэлэнгийн цахилгаан Түгээх сүлжээ ХХК, Халиун-Уул ХХК, Сэлэнгийн долгио чуулга зэрэг 15 аж ахуйн нэгж, байгууллагуудын 259 ажилтан албан хаагчид оролцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сумдаас ирүүлсэн 40 төслийг төсөл сонгон шалгаруулах комиссын хурлаар оруулж, 16 иргэнд 16 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгон шинээр 16 ажлын байр бий болголоо.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд Ерөө, Сант, Сайхан, Номгоны гүүр засварлах, үерийн далан сэргээн засварлах, төв зам сайжруулах, хорт ургамал устгах зэрэг 4 ажлыг эхлүүлэн 58 ажилгүй иргэнийг түр ажлын байраар ханган ажиллаж байна.

Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар ирүүлсэн төслүүдээс 6 сум 3 тосгоны 22 иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 30000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлэн 22 ажлын байрыг шинээр бий болгоод байна. Мөн бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд газрын асуудлаа шийдвэрлэсэн 13 сум 4 тосгоны 18 бүлэгт төмс хүнсний ногооны үр бордоо, тоног төхөөрөмж худалдан авах, хашаа хайс барих, бусад үйл ажиллагааны зардалд нийтдээ 52000.0 мянган төгрөгийг зарцуулан 54 иргэнийг улирлын чанартай ажлын байраар хангаад байна.

6. Хүүхэд залуучуудын талаар:

“Гэрээр айлчлагч” аргачлал хөтөлбөрийн хүрээнд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хэлтэс, Дэлхийн зөн Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнбүрэн, Шаамар, Дулаанхаан тосгоны нийт 31 сайн дурын идэвхтнүүдийг оролцуулан арга зүйн сургалт зохион байгууллаа.

Хүүхэд өсвөр үеийнхний дунд гэмт хэрэг, зөрчил болон болзошгүй эрсдлээс өөрийгөө болон найз нөхдөө хамгаалах, эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг таниулан сурталчлах зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газартай хамтран “Хүүхэд хууль эрх зүйн зөвлөгөө” сургалтыг зохион байгуулж, Улсын тэргүүний 1-р бүрэн дунд сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчид, анги удирдсан 17 багш, нийгмийн ажилтан, сургалтын менежер нийт 800 гаруй хүнийг хамрууллаа.

“Хүүхэд хамгааллын сар”-ын аяны хүрээнд “Хүүхэд хамгааллын тухай” хуулийг хүүхэд, эцэг эх, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд танилцуулан, сургууль, цэцэрлэг бүрийг “Хүүхэд хамгааллын бодлого” журамтай болох ажлыг эхлүүллээ.

“Хүүхдийн оролцооны байгууллагуудын ахлагч нарыг чадваржуулах нь” сургалтыг “Оюуны чадвар” төрийн бус байгууллага, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулж, 1 дүгээр шатны сургалтанд Сүхбаатар сумын 1, 2, 3, 4, 5, 6 дугаар сургууль, Спортын бүрэн дунд сургуулийн сурагч, аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүдийг хамрууллаа.

Аймгийн хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Сэтгэлийн дэм-4” аяныг “Таны тус-төлийн дуу” уриан дор өрнүүллээ.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 4 дүгээр сарын байдлаар Сант, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Ерөө, Шаамар сумын 13 хүүхэд харагч ажлын байрны дүгнэлтээ гаргуулж, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн “Би найздаа тусалж чадна” гар зураг, зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж, нийт 76 хүүхэд бүтээлээ ирүүлснээс 14 зохион бичлэг, 11 гар зургийг Хүүхдийн төлөө үндэсний газарт хүргүүлэн 65 хүүхдийн бүтээлээр үзэсгэлэн гаргалаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн хүнс хөдөө аж ахуйн газраас “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, “Монгол мал” хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөөг өөрийн аймгийн онцлогт тохируулан боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн дарга, мэргэжилтнүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, 2015 оны ажлынүр дүнг хэлэлцэж, 2016 оны зорилго зорилтоо тодорхойллоо.

Дархан Уул аймагт зохион байгуулагдсан “Улсын тариаланчдын зөвлөгөөн”-д манай аймгаас үр тариа, төмс, хүнсний ногоо эрхлэгч нийт 260 гаруй аж ахуйн нэгж, иргэд оролцлоо.

Тариалан Эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл салбараар дамжуулан эхний ээлжинд “Жница сорт”-ын 2000 тн үрийг импортолж, аж ахуйн нэгж, иргэдэд хуваарийн дагуу олгож байна.Мөн тус сангийн Сэлэнгэ салбарт 420 тн, Хөтөл салбарт 1500 тн НРК-ийн бордоог эхний ээлжинд импортолж, аж ахуйн нэгж, иргэдэд захиалгын дагуу олгож байна.

Хаврын тариалалтанд ажиллах техникийн засвар үйлчилгээ 76 хувь бол 32629 га буюу 38,7 хувьтай чийг хаалтын борной явж байна.

Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эрэлт, нийлүүлэлт, малчид, фермерийн аж ахуй эрхлэгчдийг дэмжиж, ард иргэдийг экологийн цэвэр, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Сүүтэй Монгол аян”-ыг энэ оны 04 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 30-ны хооронд зарлан зохион байгуулж байна.

Энэ онд 676912 эх мал төллөхөөс 04 дүгээр сарын 21-ны байдлаар 393585 эх мал төллөж төл бойжилт 99.5 хувьтай нийт мал төлөлт 58.1 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 394 дүгээр тогтоолын дагуу арьс шир бэлтгэж

үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн, малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмын дагуу 16 сумын 129365 ширхэг арьс ширний материалыг баталгаажуулан 569.0 сая төгрөгийн материалыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал хамгаалах санд хүргүүлээ.

Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1. Газрын харилцааны талаар:

Аймгийн Засаг даргын нэг удаагийн захирамжаар Сүхбаатар суманд одоо эзэмшиж байгаа хашааны газраа өмчлөх хүсэлт гаргасан 10 иргэнд 19019м² буюу 1,9 га 59883500 төгрөгний үнэ бүхий газрыг нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлээ.

Монгол Улсын Засгийн газрын "Монгол Улсын иргэнд 2016 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг тогтоох тухай" 2016 оны 173 тоот тогтоолыг хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болголоо.

Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжийг ажиллуулж эхэлсэний дүнд нийт 13 өргөдлийг бүртгэсэнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр 7, өмчлөх эрхээ шилжүүлсэн 1, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмших 5 иргэний өргөдлийг бүртгэж Улсын бүртгэлийн хэлтэст 8 иргэний материалыг шилжүүлж, 5 иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгов.

2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн тусгаарлах хашааны ажилд 4-р сарын 21-ны өдөр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

Сүхбаатар сумын 3-р багийн нутагт баригдаж байгаа "Усан бассейн"-ны барилгын гадна бохир усны шугамын техникийн нөхцлийн хугацаа дууссан байсныг шинэчлэн авлаа.

Мөн Сүхбаатар сумын 6-р багт баригдах ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийн барилгын цахилгаан хангамжийн техникийн нөхцлийн хугацаа дууссан тул шинэчилж авах талаар Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХХК-ийн Сэлэнгэ салбарт хүсэлт гаргалаа.

Алтанбулагийн Чөлөөт бүсийн захирагчийн албаны оффиссын барилга,Зүүнбүрэн суманд баригдах халуун ус,Сант сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын ажлын зураг төсвийг хяналаа.

3. Байгаль орчны талаар:

Шаамар сумын Охиндий 2-р багийн нутагт байрлах хуучин ашиглаж байсан хайрганы карьерт байгаль орчин нөхцөл байдлын ерөнхий үнэлгээ хийсэн газарт аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраасфото зураг авч, хэмжилт хийлээ.

Ашигт малтмалын газар, Уул уурхайн яам, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран зохион байгуулсан албажсан бичил уурхайн байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэхэд бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг ашиглах, практик ач холбогдлыг танилцуулах зорилгоор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газруудын дарга нар, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар, байгаль хамгаалагч нарыг хамарсан сургалтанд оролцлоо.

Тус аймгийн Мандал суманд мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Номголжин" ХХК, "Сансар хараа" ХХК-ын ойн мэргэжлийн байгууллагын эрх дуусч байгаатай холбоотойгоор эрх сунгуулах тухай дүгнэлт гаргуулан хүргүүлээ.

"Баялагт хос эрдэнэ" ХХК-д ойн дагалт баялгийг хамгаалах, ашиглах чиглэлээр, Хүдэр суманд ойн санг гэрээгээр эзэмшигч "Хүдэр дэлгэрэх" ХХК-д ойд

арчилгаа, цэвэрлэгээний болон ойжуулалт мод үржүүлэг, ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах мэргэжлийн байгууллагын ажил хийх дүгнэлт гаргууллаа.

Долоо.Сум орон нутгийн талаар:

1.Алтанбулаг сум:

Сэлэнгэ бүсийн “Сайн хичээл үйл ажиллагаа” арга хэмжээний тайлан арга хэмжээг зохион байгуулан Түшиг, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Алтанбулаг сумын ахлах ангийн 30 багш, 6 үндсэн чиглэлээр оролцлоо.

Сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасаг, нөхөрлөл аж ахуйн нэгжүүд хамтран ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Сүхбаатар болон Алтанбулаг сумын иргэдэд олгосон түлшний модны үлдэгдэл, гишүү, үзүүр, хожуул зэргийг ойн санг гэрээгээр эзэмшигч 12 нөхөрлөл, аж ахуйн нэгжийн 75 иргэд цэвэрлэсэн.

Аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хамтран тус сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, аж ахуйн нэгж байгууллагын ажилчид албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

2.Баруунбүрэн сум:

4 сарын 10-ний өдөр УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдсан иргэн болон фермерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн байдалтай танилцаж, иргэд, бизнес эрхлэгчтэй уулзаж санал зөвлөгөө өгч тэргүүний бизнес эрхлэгчдэд шагнал гардууллаа. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлттэй зээл олгох журам шинэчлэгдэн батлагдаж Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 52 тоот тушаалын дагуу сумын өрхийн бичил бизнес эрхлэгчдийн төслийг хүлээн авч арилцааны банкинд дамжуулан ажиллаж байна.

Монгол Улсын Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хүүхэд харах үйлчилгээг эрхлэх нэг иргэнд Хүүхэд харах үйлчилгээний байрны дүгнэлт гарган зөвшөөрөл олгон гэрээ байгууллаа.

2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр тус сумын ерөнхий боловсролын сургуулийн 2007 оны төгсөгчдийн санаачлагаар хандивын тоглолтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд сумын залуу дуучдаас гадна, төгсөгч хүүхдүүдийн урлагын номерууд багтсанаараа онцлог боллоо. Нийтдээ 300 гаруй иргэд үзсэн бөгөөд олсон орлогоо баг тус бүрээс нэг өрх сонгон авч сэтгэлийн дэм болох үүднээс гарын бэлэг гардуулан өглөө.

Тус сумын Бургалтайн 2-р багийн нутаг Магнайн шилд түймэр гарч, унтраах ажилд иргэдийг татан оролцуулж дайчилгааг зохион байгуулан бүрэн унтрааж, холбогдогч эзэнд нь хариуцуулан өгсөн. Зөрчил гаргасан этгээдэд холбогдох хуулийн дагуу захиргааны арга хэмжээ ногдуулаад байна.

3.Баянгол сум:

Сумын хэмжээнд 2016 оны тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг 2016 оны 4 дүгээр сарын 14-15-ны хооронд явагдаж нийт 793 тээврийн хэрэгсэл оношилгоонд хамрагдан, төсөв 20625200 төгрөг төвлөрүүллээ.

2016 оны самбо бөхийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд тус сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагч Э.Үнэнхүү 82 кг-ын жинд түрүүлэн, Ази болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авлаа.

Баянгол сумын нутаг дэвсгэрт шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт явуулах тухай сумын Засаг даргын 2016 оны А/42 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон хяналт шалгалтыг хугацаанд нь хийж дүнг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын Засаг даргын Тамгын газраас албан хаагчдыг 4-р сарын 21-ээс 6-р сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд батлагдсан хуваарийн хариуцлагатай жижүүрээр томилон ажиллуулж, багуудад морьт эргүүлийг томилгоожууллаа.

4.Ерөө сум:

Аймгийн Засаг даргаас 2016 онд “Хүнээ хөгжүүлж үйлдвэрлэгчдийг дэмжих” жил болгон бодлогын зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулж, Ерөө сумын Засаг дарга 2016 оны 72 тоот захирамжаартус зорилтыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулан, жилийн ажлын нээлтийг зохион байгуулж, 156 иргэн хамрагдлаа.

2016 оны 04 сарын 22-ны өдөр Ерөө сумын Засаг даргын тамгын газраас “Малчдаа сонсоё” малчдын уулзалтыг зохион байгуулж, 150 гаруй малчид хүрэлцэн ирж оролцлоо. Тус арга хэмжээний хүрээнд Ерөө сумын Засаг дарга Б.Сэргэлэн малчин иргэдтэй уулзаж, 2015 онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан тогтоол, шийдвэрийн талаар танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авлаа. Мөн уг арга хэмжээн дээр Ерөө үүлдэрийн хэсгийн хонины эр хурга жинлэх болзолт уралдааныг зохион байгуулсан.

Аймгийн "Ахмадын хорооны удирдах ажилтны зөвлөгөөн" 2016 оны 04 сарын 17-ний өдөр Ерөө сумандамжилттай зохион байгуулагдаж, нийт сум, тосгодын ахмадууд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэнгүүд оролцлоо. Мөн Сэлэнгэ аймгийн Засаг дарга С.Бүрэнбат тус арга хэмжээн дээр хүрэлцэн ирж ахмадуудаа хүндэтгэл үзүүлж сумдын ахмадын хорооны дарга нарыг шагнаж урамшууллаа.

Ерөө сумын Засаг даргын тамгын газраас 2016 оны 04 сарын 13-ны өдөр “Хүлээж биш, хүрч үйлчилье” уриан дор сумын төвөөс хол амьдардаг Буурагчин багийн малчин айл өрхүүдэдшинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийлээ.

2016 оны 04 сарын 18-ны өдөр Ерөө сумын Ерөө гол дээр баригдаж буй 272.7 у/м Төмөр бетонон гүүрний нээлтийн үйл ажиллагаа болж өндөрлөлөө.

5.Зүүнбүрэн сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Бэлчир, Мангирт багийн иргэдийн Нийтийн хурлаар дамжуулан 2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил үйлчилгээний санал асуулгыг авлаа.

Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2016 онд Зүүнбүрэн сумаас иргэдийн төлөөлөгчөөр ажиллах иргэдэд анхан шатны мэдлэг олгох зорилгоор аймгийн Шүүхийн Тамгын газартай хамтран цахим сургалтыг зохион байгууллаа.

Улс, аймаг сумын хэмжээнд улаанбурхан өвчний гарал ихсэж байгаатай холбогдуулан Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран төр төсвийн байгууллагууд, 0-5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дунд Улаанбурхан өвчний талаарх мэдээлэл болон урьдчилан сэргийлэх арга зам, мененгококкт халдвар, цагаан хорхой өвчний тухай сэдвүүдээр сургалт зохион байгуулж 91 иргэнийг хамрууллаа.

Аймгийн Цагдаагийн газар, сумын Засаг даргын Тамгын газар хамтран ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагчдын дунд “Насанд хүрээгүй иргэдээс үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, кибир гэмт хэргийн хор уршиг зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж 105 сурагчдыг хамрууллаа.

6.Мандал сум:

Тус сумын нийтийн номын сангаас зөөврийн үйлчилгээний уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Цэцэгхэн 1-р цэцэрлэг, Олимп, Монохон цэцэрлэгийн нийт 78 хүнд мэдээлэл өгч 12 хүнийг уншигчаар бүртгэн карт нээж, 313 номоор үзэсгэлэн гаргаж танилцуулга, гарын авлага 36 ширхэгийг тараасан байна. Мөн “Хүүхдийг номтой нөхөрлүүлэх нь” сэдэвт сургалтыг явуулсан.

“Дэлхийн номын өдөр” –ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулж Баянгол сум, Хэрх, Түнхэл соёлын төв, Мөнгөн Хараа дуу бүжгийн чуулга, Политехникийн коллеж, ерөнхий боловсролын сургуулийн номын санчид, ахмад номын санчид, шилдэг уншигч нарыг хамруулан спортын уралдаан тэмцээн, уулзалт зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэлтэстэй хамтранТарни 8-р багийн 32 иргэн, хорих ангиас суллагдсан 13 иргэнд “Ажилд орох арга зам” сэдэвт сургалт зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл хийлээ.

Хуурайшилтын онцгой үе эхэлж байгаатай холбогдуулан 04-р сарын 05-наас 06-р сарын 10-ныг хүртэлх хугацаанд ойд аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглож, ойн сангийн 7 чиглэлд төв постууд ажиллуулан, мод бэлтгэл үйлдвэрлэлийн 30 нөхөрлөл, 36 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоогоод байна.

7.Орхон сум

Аймгийн Засаг даргын 2016 оны А/74 тоот захирамжийн хүрээнд сумын Засаг даргын 2016 оны А/73 тоот захирамж гарч “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийг сайжруулах судалгаа, үнэлгээ хийх” ажлын хэсэг байгуулагдан суманд үйл ажиллагаа явуулж буй 5 төр төсвийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэд бүтцийг сайжруулах талаар хяналт шалгалт хийж цаашид сайжруулах ажлын талаар зөвлөмж хүргүүлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүд 2016 оны 04-р сарын 20-ны өдөр Орхон суманд ажиллаж сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажилдхяналт шалгалт хийж сумын иргэдтэй уулзалт зохион байгуулан гэмт хэргийн өсөлт, бууралт, гарх шалтгаан нөхцөл, согтууруулах ундааны хэрэглээний мэдээлэл хийлээ.

Орхон сумын Засаг даргын Тамгын газар Сайхан сумын цагдаагийн хэсэгтэй хамтран сумын төр, төсвийн байгууллагын ажилчид, албан хаагчдад “Замын хөдөлгөөний дүрмийн өөрчлөлт, согтууруулах ундаанаас татгалзъя” сургалтыг зохион байгууллаа.

2016 онд 10 төрлийн вакцинжуулалтанд 48,3 мянган толгой мал хамруулахаар сумын Засаг дарга, мал эмнэлгүүд гэрээ байгуулан сумын Засаг даргын 2016 оны А/56 тоот “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ явуулах тухай” захирамжийн дагуу вакцинжуулалтын ажил эхлээд байна.

8.Сайхан сум:

2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр тус сумын Засаг даргын Тамгын газраас аймгийн 9 бахархал, байгалийн үзэсгэлэнт 9 газар, түүх соёлын дурсгалт 9 газрыг иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Сайхан сумын нохой муурыг гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Орхон, Дархан-Уул аймгаас туршлага судлан нохой, муурын эзэдтэй хийх гэрээний загвар болон олнох үнэмлэхний загварыг хийн холбогдох шийдвэрүүдийг гаргуулан бэлтгэл ажлы хангаж байна.

Хүүхдийн зохиолчдын уран бүтээлийг таниулан сурталчилж, хүүхэд багачуудыг нээн хөгжүүлэх зорилгоор “Уран жиргээ 2016” уран уншлагын уралдааны эхний шатны шалгаруулалтыг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Аймгийн Эрүүл мэндийн газар, сум дундын эмнэлэг хамтран сумын 0-1 насны болон суурь өвчтэй нийт 225 хүүхдээс 196 хүүхдийг гэрээр очиж эрүүл мэндийн үзлэгт хамруулан гарын авлага тарааж, эцэг, эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө өглөө.

9.Цагааннуур сум:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 193 тоот тогтоолоор батлагдсан Улсын тэргүүний сум шалгаруулах болзлыг ханган Цагааннуур сум “Улсын Тэргүүний сум”-аар шалгарлаа.

Тайлант нь ахуйн тухай хууль, сум хөгжүүлэх сангийн зээл, түүний эргэн төлөлтийн талаар мэдээлэл хийлээ.

2016 оны 04 сарын 20-ны өдөр “Шүрэнгийн усан цахилгаан станц” байгуулах төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлын даалгаврын талаарх хэлэлцүүлэгийг зохион байгуулж, иргэд идэвхтэй оролцон, санал сэтгэгдэлээ хуваалцлаа.

Нийслэл, сум, дүүргийн төлөөлөгчид, төрийн байгуулалтын ажилтан, иргэд, 24 ахуйн тухай хууль, сум хөгжүүлэх сангийн зээл, түүний эргэн төлөлтийн талаар мэдээлэл хийлээ.

10.Хушаат сум:

Сумын 30 жилийн ой 2017 онд болохтой холбогдуулан Улаанбаатархот, Дархан-Уул аймагт Нутгийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж зөвлөлийг шинэчлэн зохион байгуулж ойн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө, зохион байгуулалтын асуудлуудыг шийдвэрлэлээ.

Захиргааны Ерөнхий хууль болон Нэмэн өртөгийн албан татварын тухай хуулиудын 2 өдрийн сурталчилгааны өдөрлөгийг зохион байгууллаа.

Орон нутаг судлах танхимаас нийт 55 иргэнд үйлчлэн “Орон нутгаа танин мэдэцгээ” сэдэвт бага насны хүүхдүүдийн сумын музейтай танилцах аялалыг зохион байгууллаа.

Тайлант сард сумын тариаланчид, ногоочдын зөвлөгөөнийг зохион байгуулж энэ оны тариалалтын ажил, Тариалангийн тухай хууль, цаг агаарын мэдээ зэрэг мэдээллүүдийг өгч тариалалтын арга зөвлөмж гаргалаа.

2 жил газраа ашиглаагүй байгууллага, иргэдийн ногооны газрыг хураан авч дахин хуваарилах ажлыг зохион байгууллаа.

11.Хүдэр сум:

Сумын Засаг даргын Тамгын газар ахмадын хороотой хамтран “Ахмад настны нийгмийн хамгааллын тогтолцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Хамтын тэтгэвэрийн тухай хууль, Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хүүхэд харах үйлчилгээний талаар мэдээлэл хийж, 40 гаруй ахмадуудыг хамрууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас Аж үйлдвэрийн яамнаас ирсэн мэргэжилтнүүдтэй хамтран Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 48 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор шинэчлэн батлагдсан журам” болон төсөл хөтөлбөрт тавигдах шаардлага цаашид анхаарах асуудлуудын талаар сургалт зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Улаан загалмайн хороотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй, цөөн малтай, орлого багатай ам бүл болон зарим малчдад мөнгөн тусламж үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтэстэй хамтран тус сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 3 зоогийн газар, 26 дэлгүүрт хяналт, шалгалт хийж, баталгаажуулалтын ажлыг зохион байгууллаа.

12.Шаамар сум:

Аймгийн Эрүүл Мэндийн Газрын Халдварт өвчин судлалын тасгаас тус суманд ажлын хэсэг ажиллан, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхэд, багш ажилчдаас шаардлагатай шинжилгээг авч мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Аймгийн Онцгой байдлын газар, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Болзошгүй байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх” талаар мэргэжлийн анги, бүлгүүдэд сургалт зохион байгууллаа.

Австралийн Засгийн газрын буцалтгүй Тусламжийн сан “Ой хамгаалал ба Өрхийн амьжиргааг дээшлүүлэх төсөл” хөтөлбөрийн хүрээнд Австралийн Засгийн газрын төлөөлөгч Конрад Буленда, Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагаасойг нөхөн сэргээх, ойжуулах, байгалийн баялагийн зохистой ашиглалтыг дэмжих, Зөгийн аж ахуй эрхлэлтийг дэмжих тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх төслийн талаар зөгийн аж ахуй эрхэлдэг бүлгийн гишүүдэд сургалт мэдээлэл хийлээ.

Улаан бурхан өвчний дэгдэлт их байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нарын бүрэлдэхүүнтэй хамтран багийн 0-5 насны хүүхэдтэй өрхүүдээр явж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж ажиллалаа.

13.Түшиг сум:

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2016 оны 19-р зарлигаар төрийн дээд одон медаль “Алтан гадас” одонгоор тус сумын иргэн ахмад настан О.Бэнсэрд, Д.Ганбаатар, С.Баянжаргал,” Хөдөлмөрийн хүндэм медаль”-иар Ю.Раднаа, Б.Алтаншагай, Л.Батчулуун, Ш.Лхагва, Б.Лхагважав, Д.Мөнхбаатар нар шагнагдлаа.

Улс орон даяар аж ахуйн нэгж байгууллагуудын улсын тооллого явагдаж байгаатай холбогдуулан 2016 оны 4-р сарын 1-ээс 5-р сарын 1-ний өдрийг хүртэл сумын Засаг даргын 2016 оны А/30 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан сумын хэмжээний аж ахуй нэгж байгууллагуудыг 100 хувь тоолж дуусгалаа.

Сэлэнгэ бүсийн ахмадуудын дуун цэнгүүн “Цэнхэр дурдан алчуур” арга хэмжээ Түшиг суманд амжилттай зохион байгуулагдаж Хушаат, Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур сумдын 4 баг урлагийн 5 төрлөөр өрсөлдөж, нийт 180 гаруй ахмад настнууд хамрагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид “Бидний тус-*төлийн дуу” уриан дор ишиг хурганы элгэвч, тугалын нэмнээ, скоч, хурганы уут зэрэг малчдад мал төллөхөд нэн чухал шаардлагатай байсан зүйлсийг хуримтлуулж, нийт 432 тооны эд зүйлсийг цуглуулан малчин 48 өрхөд хуваарилж өглөө.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР